



62

**ХЭНТИЙ АЙМГИЙН  
БИНДЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2026 оны 04 сарын 07 өдөр

Дугаар А/48

Биндэр сум

**Эмэгтэйчүүдийн зөвлөл  
байгуулах тухай**

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Биндэр сумын эмэгтэйчүүдийн зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Зөвлөлийн дарга:	Э.Оюунболор	Хувийн хэвшил
Гишүүн:	О.Ариунзаяа	1-р багийн төлөөлөл
	Э.Хулан	2-р багийн төлөөлөл
	Г.Нарантуяа	3-р багийн төлөөлөл
	О.Ариунчимэг	4-р багийн төлөөлөл
	Т.Хулан	5-р багийн төлөөлөл
	Т.Дэлгэрмаа	Ерөнхий боловсролын сургууль
	П.Нэргүй	Эрүүл мэндийн төв
	Б.Болортунгалаг	Хүүхдийн цэцэрлэг
	Г.Гэгээнжаргал	Соёлын төв
Нарийн бичиг:	Б.Жавзандулам	Аж ахуйн нэгж

2. Зөвлөлийн дүрмийг хавсралтаар баталж хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын мэргэжилтэн (Б.Золбоо)-д даалгасугай.

3. Эмэгтэйчүүдэд чиглэсэн үйл ажиллагааг жил бүр төлөвлөн хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг эмэгтэйчүүдийн зөвлөлд үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ДЭМБЭРЭЛСАЙХАН

Хүлээн авсан  
Хүлээн авсан  
Хүлээн авсан

Засаг даргын ~~нөдөр~~ ~~оны~~ ~~дүгээр~~ сарын ~~07~~-ны  
өдрийн ~~1/1~~ захирамжийн хавсралт

## БИНДЭР СУМЫН ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЗӨВЛӨЛИЙН ДҮРЭМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү дүрмийн зорилго нь Биндэр сумын эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх, эрх ашгийг хамгаалах, нийгэм, эдийн засаг, эрүүл мэнд, боловсролын чиглэлээр дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг зохион байгуулахад оршино.

1.2. Биндэр сумын Эмэгтэйчүүдийн зөвлөл (цаашид "Зөвлөл" гэх) нь сайн дурын үндсэн дээр үйл ажиллагаа явуулах олон нийтийн байгууллага байна.

1.3. Зөвлөл нь үйл ажиллагаандаа Монгол Улсын хууль тогтоомж болон энэхүү дүрмийг мөрдөнө.

### Хоёр. Зорилго, зорилт

- 2.1. Эмэгтэйчүүдийн нийгмийн оролцоог нэмэгдүүлэх
- 2.2. Гэр бүл, хүүхэд, эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах
- 2.3. Эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих
- 2.4. Сургалт, уулзалт, нөлөөллийн ажлууд зохион байгуулах
- 2.5. Сайн үйлс, нийгмийн хариуцлагын ажлуудыг дэмжих

### Гурав. Зөвлөлийн бүтэц, зохион байгуулалт

- 3.1. Зөвлөл нь дарга, дэд дарга, нарийн бичгийн дарга, гишүүдээс бүрдэнэ.
- 3.2. Зөвлөлийн даргыг гишүүдийн олонхын саналаар 2 жилийн хугацаатай сонгоно.
- 3.3. Зөвлөлийн гишүүн нь сайн дурын үндсэн дээр элсэж, гарч болно.
- 3.4. Шаардлагатай тохиолдолд ажлын хэсэг байгуулж ажиллуулна.

### Дөрөв. Эрх, үүрэг

4.1. Зөвлөл нь дараах эрхтэй:

- Үйл ажиллагаа санаачлах, зохион байгуулах
- Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдтэй хамтран ажиллах
- Санал, хүсэлт гаргах, шийдвэр гаргалтад оролцох

4.2. Зөвлөлийн гишүүд дараах үүрэгтэй:

- Дүрэм, журмыг мөрдөх
- Идэвхтэй оролцох
- Ёс зүйг сахих
- Нууцлалыг хадгалах

### **Тав. Үйл ажиллагааны чиглэл**

- 5.1. Сургалт, уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулах
- 5.2. Нийгмийн сайн сайхны төлөө аян, арга хэмжээ хэрэгжүүлэх
- 5.3. Эрүүл мэнд, боловсролын чиглэлээр мэдээлэл, зөвлөгөө өгөх
- 5.4. Эмэгтэйчүүдийг дэмжих төсөл, хөтөлбөр санаачлан хэрэгжүүлэх

### **Зургаа. Санхүү, эх үүсвэр**

6.1. Зөвлөлийн үйл ажиллагаа нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ:

- Хандив, тусламж
- Төсөл, хөтөлбөрийн санхүүжилт
- Бусад хуульд нийцсэн эх үүсвэр

6.2. Санхүүгийн үйл ажиллагааг ил тод явуулж, тайлагнана.

### **Долоо. Хурал, шийдвэр гаргалт**

- 7.1. Зөвлөлийн хурал улиралд 1 удаа хуралдана.
- 7.2. Шийдвэрийг олонхын саналаар гаргана.
- 7.3. Шаардлагатай тохиолдолд ээлжит бус хурал зарлаж болно.

### **Найм. Хариуцлага**

- 8.1. Дүрэм, журам зөрчсөн гишүүнд сануулах, чөлөөлөх арга хэмжээ авч болно.
- 8.2. Ёс зүйн зөрчил гаргасан тохиолдолд хурлаар хэлэлцэн шийдвэрлэнэ.

### **Ес. Дүрэмд өөрчлөлт оруулах**

- 9.1. Дүрэмд өөрчлөлт оруулах саналыг гишүүд гаргана.
- 9.2. Өөрчлөлтийг Зөвлөлийн хурлаар хэлэлцэж батална.